



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр.  
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: info@mojha.gov.mn,  
Вэбсайт: www.mojha.gov.mn

2021.03.10 № 1/1117

танай 2021.03.03 -ны № 21/308 -Т

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА  
Г.ЧИНЗОРИГ ТАНАА**

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
“Радио холбооны сүлжээ сарниулах тоног  
төхөөрөмж ашиглах журам батлах тухай” 2020  
оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 69 дүгээр  
тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу  
хянан үзээд Захиргааны хэм хэмжээний актын  
улсын нэгдсэн бүртгэлийн ..... дугаарт  
бүртгэснийг үүгээр мэдэгдье.



151601214  
Doc.yam a5.2021

МОНГОЛЫН ХАА ХОЛБОСНЫ  
• ХАА ХОЛБОСНЫ  
ТТН.Э.2053

Бүртгэсэн № ... карт № 587  
Өдөр 2021. 03. 12 ...  
14 цаг 30 минутанд  
... д  
... д

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2021 оны 03 сарын 10-ны  
өдрий 5113 дугаарт бүртгэв.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

“Радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж  
ашиглах журам” батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, Радио  
долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.9 дэх заалтуудыг үндэслэн тус тус  
ТОГТООХ нь:

1. “Радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам”-ыг энэхүү  
тогтоолын хавсралт ёсоор баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-  
д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ



Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн  
69 тоот тогтоолын  
хавсралт

## **РАДИО ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ САРНИУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХ ЖУРАМ**

### **НЭГ.**

#### **Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь Төрийн болон албаны нууц задрахаас хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор Радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж /цаашид “Сарниулах төхөөрөмж” гэх/-ийг ашиглах, тэдгээрт хяналт тавихтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд тусгайлсан заасан хууль, дүрэм, журмын дагуу зохицуулагдаж байгаа гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах зэрэг нууц ажиллагаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед энэхүү журмыг мөрдөхгүй.

1.3. Тусгайлан заасан хууль, дүрэм, журмаар зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагууд нь энэхүү журмын 1.2-т зааснаас бусад зорилгоор Радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмжийг ашиглах тохиолдолд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4. Сарниулах төхөөрөмжийг ашиглах зориулалт, хүчин чадал, хамрах хүрээнээс хамааран байнгын болон байнгын бус ажиллагаатай гэж хуваах бөгөөд байнга, суурин ашиглах зорилгоор барилга байгууламж, тасалгааг тусгайлан тоноглохыг байнгын ажиллагаатай, тогтмол нэг байршилд бус, зөөврийн сарниулах төхөөрөмжийг барилга байгууламж, тасалгаанд зөөвөрлөн ашиглахыг байнгын бус ажиллагаатай гэнэ.

### **ХОЁР.**

#### **Сарниулах төхөөрөмж ашиглах хүсэлт гаргах, шийдвэрлэх**

2.1. Сарниулах төхөөрөмж ашиглах хүсэлт гаргах.

2.1.1. Сарниулах төхөөрөмж ашиглахаар хүсэлт гаргагч этгээд нь Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/-нд албан хүсэлтээ энэхүү журмын хавсралт 1-д заасан өргөдлийн маягтын хамт ирүүлнэ.

2.1.2. Зохицуулах хороо нь сарниулах төхөөрөмж ашиглах тухай хүсэлтийг шийдвэрлэхдээ Тагнуулын байгууллагаас санал авна.

2.1.3. Зохицуулах хороо нь энэхүү журмын 2.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэж, хариу хүргүүлнэ.

2.2. Байнгын ажиллагаатай сарниулах төхөөрөмж ашиглах хүсэлтийг шийдвэрлэх.

2.2.1. Зохицуулах хороо нь ирүүлсэн хүсэлтэд үндэслэн дараах асуудлыг тодруулан хэмжилт хийж, үнэлгээ, дүгнэлт гаргана. Үүнд: